

87

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ЖИНСТ СУМЫН
ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХОРОО**

2026 оны 04 дүгээр сарын 21

Дугаар 03

Бодь

**ЖИНСТ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Б.АЛТАНХУЯГ ТАНАА**

Зөвлөмж хүргүүлэх тухай


Монгол улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 28 дугаар зүйлийг үндэслэн Жинст сумын үндэсний бөхийн дэвжээ худалдан авах” бараа нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хорооны 2026 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдааны шийдвэрийг хүргүүллээ.


Энэ тендер нь харьцуулалтын аргаар тендер сонгон шалгаруулалтын журмын аргаар явагдаж, оролцогчдыг өрсөлдөх тэгш боломжоор хангасан. Тендерийг цахимаар нээхэд хоёр компани оролцож, үнийн саналыг холбогдох бичиг баримтын хамт ирүүлсэнийг холбогдох хууль, журмын дагуу үнэлсэн болно.

1. Арвин хонгор ХХК-ны ирүүлсэн тендерийн материал, 40,000,000 (Дөчин сая) төгрөгийн үнийн санал нь шаардлага хангаж байгаа тул гэрээ байгуулж хамтран ажиллахыг зөвлөж байна.

2. Өнөр Баян Богд ХХК, ирүүлсэн тендерийн материал шаардлага хангаж байгаа хэдий ч харьцуулах үнийн санал өндөр тул гэрээ байгуулах эрх олгохоос татгалзаж байна.

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 27 дугаар зүйл, 28 дугаар зүйлийг тус тус үндэслэн шийдвэр гаргасан болно.

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ДАРГА  Т.НАРАНБААТАР
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Б.ХАШЧУЛУУН
ГИШҮҮД Б.БАТБАЯР

 Н.ЭРДМАА
А.НЯМДОРЖ



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЖИНСТ СУМЫН
ЗАСАГ ДАРГА**

1-114 дүгээр байр, Таван элс, Бодь 5 дугаар баг, Жинст
сум, Баянхонгор аймаг, 64073 Утас:91118506
Цахим шуудан: info@jinst.bkh.gov.mn

“АРВИН ХОНГОР ХХК”-Д

2026.04.23 № 10/33

танай _____-ны № _____-т

Гэрээ байгуулах эрх олгох тухай

“Үндэсний бөхийн дэвжээ худалдан авах” бараа нийлүүлэх ажлын сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хорооны шийдвэр, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 28 дүгээр зүйлийн 28.1.1 дэх заалтыг үндэслэн МЭДЭГДЭХ нь:

1. “АРВИН ХОНГОР ХХК” нь тус ажлыг 40,000,000 (Дөчин сая) төгрөгөөр хийж гүйцэтгэхээр үнийн санал холбогдох материалыг ирүүлсэн нь үнэлгээний хорооны гишүүдийн санал, тендерт оролцохоор ирүүлсэн материалыг нэг бүрчлэн үнэлсэн үнэлгээний дүнгүүдийг үндэслэн энэхүү тендерт “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер гэж үзэж тус аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулах эрх олгож байна.

2. Гэрээг гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдснээс хойш ажлын 6-аас доошгүй өдрийн дараа, тендер хүчинтэй байх хугацаанд багтааж байгуулна уу.

ДАРГА

Б.АЛТАНХУЯГ

642504058

